



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/141/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор:
Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.08.13 № 39

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ П.ХОНГОРЗУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны орлогыг 3380.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 34 хувийн 1170.0 мянган төгрөгийн орлого оруулж, 2210.0 мянган төгрөгийн орлого дутуу оруулжээ.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Соёл урлагийн газраас 9 төрлийн 10934.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, байгууллагын эзэмшлийн газрыг 5628.0 мянган төгрөгөөр үнэлж үндсэн хөрөнгийн тодруулга тайланд бүртгэн орлогод авч тайлагнажээ.

006020041

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 5 зорилтын хүрээнд 26 ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 3 зорилтын 23 ажлын биелэлт бүрэн хангагдаж, 2 зорилтын 3 ажил дутуу биелэгдэж 92.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,854,740.00	37,718,601.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	15,606,261.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	15,606,261.18
3121	Төгрөг	-	15,606,261.18
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	15,606,261.18
35	БАРАА МАТЕРИАЛ	17,854,740.00	22,112,340.00
354	Хангамжийн материал	17,854,740.00	22,112,340.00
35420	Аж ахуйн материал	-	964,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,854,740.00	21,148,340.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,023,359,912.03	1,022,085,667.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,023,359,912.03	1,022,085,667.56
392	Биет хөрөнгө	1,022,526,578.73	1,014,324,334.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,024,011,779.75	1,024,011,779.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,748,749.47)	(49,656,622.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,232,003.70	28,053,601.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,178,503.62)	(4,637,032.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,236,010.20	11,574,392.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,509,022.83)	(8,004,844.39)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12,483,061.00	12,983,061.00
393	Биет бус хөрөнгө	833,333.30	7,761,333.26
39301	Програм хангамж	1,000,000.00	2,500,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	(166,666.70)	(366,666.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	5,628,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,041,214,652.03</u>	<u>1,059,804,268.74</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,041,214,652.03</u>	<u>1,059,804,268.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,041,214,652.03	1,059,804,268.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48,626,586.94	48,626,586.94
512	Хуримтлагдсан үр дүн	846,002,614.82	864,592,231.53
51210	Өмнөх үеийн үр дүн	846,002,614.82	846,002,614.82
51220	Тайлант үеийн үр дүн	-	18,589,616.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	146,585,450.27	146,585,450.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,041,214,652.03</u>	<u>1,059,804,268.74</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	997,302,532.00	242,326,990.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	866,946,032.00	22,654,101.04
120	Нийтлэг татварын бус орлого	866,946,032.00	22,654,101.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	882,500.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	865,813,532.00	22,654,101.04
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	250,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	130,356,500.00	219,672,889.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	47,059,100.00	104,062,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,059,100.00	104,062,100.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	1,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,170,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	78,297,400.00	113,640,789.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,297,400.00	113,640,789.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	89,366,528.07	223,737,373.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,366,528.07	223,737,373.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,954,596.07	203,805,873.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,913,800.00	52,213,310.00
210101	Үндсэн цалин	51,306,800.00	44,536,242.00
210102	Нэмэгдэл	9,607,000.00	5,902,585.00
210104	Урамшуулал	-	1,774,483.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,785,820.00	6,425,064.82
210201	Тэтгэврийн даатгал	4,927,810.00	4,431,130.48
210202	Тэтгэмжийн даатгал	911,923.20	522,133.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	401,867.22	417,706.54
210204	Ажилгүйдлийн даатгал	226,987.94	95,826.64
210205	Эрүүл мэндийн даатгал	1,317,231.64	958,268.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,024,848.00	99,529,423.00
210301	Гэрэл, цахилгаан	1,264,848.00	1,520,057.00
210302	Түлш, халаалт	4,760,000.00	98,009,366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,000.00	1,278,125.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	156,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	451,325.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	60,000.00

210408	Бараа материал акталсны зардал	-	535,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	340,500.00	11,627,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,500.00	-
210604	Урсгал засвар	300,000.00	11,627,600.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	586,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,408,720.00	4,586,305.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	408,720.00	4,586,305.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,099,908.07	27,560,045.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	381,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,099,908.07	27,178,345.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	411,932.00	19,931,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	19,931,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,163,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	211,932.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,932.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>907,936,003.93</u>	<u>18,589,616.71</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>907,936,003.93</u>	<u>18,589,616.71</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	131,239,000.00	219,672,889.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	882,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	882,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	882,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	130,356,500.00	219,672,889.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	47,059,100.00	104,062,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,059,100.00	104,062,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	1,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,170,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	78,297,400.00	113,640,789.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,297,400.00	113,640,789.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	78,797,400.00	200,816,627.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,797,400.00	200,816,627.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,385,468.00	180,885,127.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,913,800.00	52,213,310.00
210101	Үндсэн цалин	51,306,800.00	44,518,242.00
210102	Нэмэгдэл	9,607,000.00	5,920,585.00
210104	Урамшуулал	-	1,774,483.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,785,820.00	6,425,064.82
210201	Тэтгэврийн даатгал	5,408,220.00	4,431,130.48
210202	Тэтгэмжийн даатгал	594,300.00	522,133.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	453,400.00	417,706.54
210204	Ажилгүйдлийн даатгал	141,300.00	95,826.64
210205	Эрүүл мэндийн даатгал	1,188,600.00	958,268.06

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,024,848.00	99,529,423.00
210301	Гэрэл, цахилгаан	1,264,848.00	1,520,057.00
210302	Түлш, халаалт	4,760,000.00	98,009,366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,000.00	896,225.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	156,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	425,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	12,727,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	11,627,600.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	586,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,900,000.00	5,217,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	5,217,505.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,290,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,290,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	411,932.00	19,931,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	19,931,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,163,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	211,932.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,932.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,441,600.00	18,856,261.18

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,382,500.00	3,250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,382,500.00	3,250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,382,500.00	3,250,000.00
222001	Тоног төхөөрөмж	5,382,500.00	2,750,000.00
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,382,500.00)</u>	<u>(3,250,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46,059,100.00	15,606,261.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,606,261.18

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-

C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,626,586.94	146,585,450.27	846,002,614.82	-	1,041,214,652.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	18,589,616.71		18,589,616.71
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,626,586.94	146,585,450.27	864,592,231.53	-	1,059,804,268.74

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206407800.00	204066627.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206407800.00	200816627.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	186476300.00	180885127.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65985400.00	52213310.00

210101	Үндсэн цалин	50475000.00	44518242.00
210102	Нэмэгдэл	9737900.00	5920585.00
210104	Урамшуулал	5772500.00	1774483.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8253300.00	6425064.82
210201	Тэтгэврийн даатгал	5612200.00	4431130.48
210202	Тэтгэмжийн даатгал	660200.00	522133.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	528300.00	417706.54
210204	Ажилгүйдлийн даатгал	132100.00	95826.64
210205	Эрүүл мэндийн даатгал	1320500.00	958268.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88234200.00	99529423.00
210301	Гэрэл, цахилгаан	1520100.00	1520057.00
210302	Түлш, халаалт	86714100.00	98009366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	721800.00	896225.00
210401	Бичиг хэрэг	156000.00	156000.00
210402	Тээвэр, шатахуун	250800.00	425225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,727,600.00	12,727,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	11,627,600.00	11,627,600.00
2107	Томилолт, зочны зардал	586,000.00	586,000.00
210702	Дотоод албан томилолт	586,000.00	586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,968,000.00	6,507,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,968,000.00	6,507,505.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,931,500.00	19,931,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,931,500.00	19,931,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,163,500.00	19,163,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,250,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,750,000.00
223001	Бусад хөрөнгө	-	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	206,407,800.00	217,702,889.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	104,062,100.00	104,062,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	104,062,100.00	104,062,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	102,345,700.00	113,640,789.00
132001	Орон нутгийн төсвөөс	102,345,700.00	113,640,789.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,606,261.18
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4
620003	Үйлчлэх ажилтан	1	1
620004	Гэрээт ажилтан	0	0

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,970,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,970,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,970,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	680,000.00
210402	Тээвэр, шатахуун	180,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,290,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,290,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,970,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,170,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ сумын Соёлын төв нь Иргэдийн оюун санааны хэрэгцээг хангах үүрэг бүхий мэдээлэл, урлаг, соёл, спортын цогц төв болохоор доорхи зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Үүнд:

- Булган аймгийн соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг хангах
- Ардын болон орчин үеийн соёл урлагийн үйлчилгээг олон талт хэлбэрээр хүргэх
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих
- Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэж, иргэдэд спортоор хичээллэх таатай

орчин бүрдүүлэх гэсэн жил 5 зорилтын хүрээнд 26 ажил төлөвлөснөөс 23 бүрэн биелэгдэж 92.3 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг жмөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг шалгахаар горим хэрэгжүүлсэн.

Горим сорилгоор өөрийн орлогыг 3380.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1170.0 мянган төгрөг буюу 34 хувийн орлого оруулж, 2210.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-ыг шинэчлэн батлаагүй 2020 онд баталсан бодлогыг баримтлан ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй 2020 онд батлагдсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.1 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	15606.3	15606.3
Авлага	0	0	0
Бараа материал	17854.7	22112.3	4257.6
Үндсэн хөрөнгө	1023359.9	1022085.7	-1274.2
Нийт хөрөнгө	1041214.6	1058304.3	17089.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	48626.6	48626.6	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1041214.6	1058304.3	17089.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 4257.6, үндсэн хөрөнгө 2774.2 мянган төгрөгөөр буурч, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 15606.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаснаар нийт хөрөнгийн хэмжээ 17089.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 123.7, орон нутгийн төсвөөс 88.7, үйл ажиллагааны орлогоос 1.8 сая төгрөгөөр буюу нийт 214.2 сая төгрөгөөр санхүүжилтийн эх үүсвэрийг тооцон нийт зарлагыг 214.2 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналын дүнгээс 19.9 сая төгрөгөөр бууруулан, 194.3 сая төгрөгөөр төсвийг баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2022 оны 06 сарын 30-ны өдрийн 09/03 тоот тогтоолоор төсөвт нэмж тодотгол оруулан 6.0 сая төгрөгөөр зардлыг нэмэгдүүлж нийт 200.4 сая төгрөгөөр баталж өөрчлөлт оруулжээ.

Тодотголоор зардал нэмэгдсэн шалтгаан нь атар багийн цогцолбор баригдсантай холбоотойгоор байр тогтмол зардлыг нэмэгдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 104.1, орон нутгийн төсвөөс 113.6, өөрийн үйл ажиллагааны орлогын хүрээнд 1.2, Соёл урлагийн газраас 0.8 сая төгрөг буюу нийт 219.7 сая төгрөгийн санхүүжилт авч 204.1 сая төгрөгийг зарцуулж үндсэн үйл ажиллагааны дансанд 15.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 204.1 сая төгрөг буюу 92.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	81130.6	65524.3	-15606.3	81
2	Уран бүтээл хийлгэх	3000.0	3000.0	0	100
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	19931.5	19931.5	0	100
4	Төрийн өмчийн байр ашиглалтай холбоотой зардал	99861.8	111157.0	11295.2	111
5	Нийтлэг үйлчилгээ	2483.9	2483.7	-0.2	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Соёл урлагын газраас 0.8, өөрийн үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөг буюу нийт 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт дансаар авч гүйцэтгэлээр Соёлын бүтээлч сарын ажилд 0.3, номын зардалд 0.5, бусад зардалд 1.0, шатахууны зардалд 0.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 219672.8 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 2471.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь цалингийн зардлыг 13.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Цалингийн зардал хэмнэгдсэн шалтгаан нь жилийн дунд бүжгийн багш, мужаан гэсэн 2 орон тоо гүйцэд ажиллаагүйтэй холбон үзэж байна.

Тайлант онд халаалтын зардлыг 86.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 98.0 сая төгрөгийг зарцуулж илүү 11.3 сая төгрөгийн зардал хэтэрсэн боловч сумын орон нутгийн зарлагын данснаас зарлага гаргах эрхийг нээсэн байсныг нягтлан бодогч батлагдсан халаалтын зардлын дүнтэй тулгахгүйгээр гүйлгээ хийж авлага өглөггүй тайлагнасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 149 мэдээ мэдээлэхээс 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бараа үйлчилгээний бусад зардлын 298.0 мянган төгрөгийг томилолтын зардалд шилжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу зарцуулаагүй, бүлэг хооронд шилжүүлэх албан тоот, хүсэлтийг хүргүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг 34 хувиар буюу 1170.0 мянган төгрөг оруулж 2210.0 мянган төгрөгөөр дутуу оруулсан Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.9. "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх,” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Шилэн дансанд мэдээлэх мэдээллүүдээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан төсөв гэсэн 4 мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроосон зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;" 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 9-д "хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Сэлэнгэ сумын Соёлын төв нь 2022 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 12 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, тогтмол зардлыг бодитой үнэн зөв төлөвлөж, орлогын гүйцэтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн алдаа¹ илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бусад зардлын 0.3 сая төгрөгийг томилолтын зардалд шилжүүлэн зарцуулсан.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу зарцуулж ажиллах.

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өөрийн орлогыг 3.4 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1.2 сая төгрөг буюу 34 хувиар орлого оруулж 2.2 сая төгрөгийн орлого дутуу оруулж ажилласан.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны орлогыг бодитой, үнэн зөв төлөвлөж, орлогын гүйцэтгэлийг ханган ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан төсөв гэсэн 4 мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

		/мянган төгрөгөөр/	
Нийт зөрчил	Үүнээс		

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусад зардлаас томилолтын зардалд шилжүүлэн зарцуулсан.	1	298.0					1	298.0				
Өөрийн үйл ажиллагааны орлого дутуу.	1	0					1	0				
Дүн	2	298.0					2	298.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэх 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0					1	0